



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 12 сарын 17 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

## ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “эрүүл мэнд, хувийн харилцааны нууц,” гэснийг “хувийн мэдээлэл,” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалтын “эрүүл мэнд, хувийн нууцыг” гэснийг “хувийн мэдээллийг” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР